



MAGIC
CONSULTING AUDIT

АУДИТ
БАТАЛГААЖУУЛАХ
ҮЙЛЧИЛГЭЭ

**СИМПЛ АССЕТ ТЗК ХХК-ИЙН
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР
ТАСАЛБАР БОЛГОСОН ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

**АУДИТОРЫН
ТАЙЛАН**

| АГУУЛГА | ХУУДАС |
|--|---------------|
| КОМПАНИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ | 1 |
| УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ | 2 |
| ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН | 3-4 |
| САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН | 5 |
| ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН | 6 |
| ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН | 7 |
| МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН | 8 |
| Тодруулга 1 Тайлагнагч аж ахуйн нэгж | 9 |
| Тодруулга 2 Тайлан бэлтгэсэн үндэслэл | 9 |
| Тодруулга 3 Шинээр батлагдсан, нэмэлт өөрчлөлт орсон стандарт болон тайлбарууд | 10 |
| Тодруулга 4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо | 11 |
| Тодруулга 5 Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө | 13 |
| Тодруулга 6 Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 13 |
| Тодруулга 7 Дансны болон бусад авлага | 13 |
| Тодруулга 8 Богино хугацаат өрийн бичиг | 13 |
| Тодруулга 9 Дансны болон бусад өглөг | 13 |
| Тодруулга 10 Орлогын албан татварын өглөг | 13 |
| Тодруулга 11 Хувьцаат капитал | 14 |
| Тодруулга 12 Хуримтлагдсан ашиг (алдагдал) | 14 |
| Тодруулга 13 Хүүгийн орлого | 14 |
| Тодруулга 14 Хүүгийн зардал | 14 |
| Тодруулга 15 Зээлийн эрсдэлийн сангийн зардал | 14 |
| Тодруулга 16 Үйл ажиллагааны бусад зардал | 14 |
| Тодруулга 17 Орлогын татварын зардал | 14 |
| Тодруулга 18 Холбоотой талуудын тодруулга | 15 |
| Тодруулга 19 Хүлээж болзошгүй үүрэг хариуцлага | 15 |
| Тодруулга 20 Тайлангийн дараах үйл явдал | 15 |

КОМПАНИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

| | | | |
|--------------------------|---|---------------|----------------|
| Үүсгэн байгуулах шийдвэр | Симпл Ассет ТЗК ХХК (Цаашид “Компани” гэх) нь анх 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр үүсгэн байгуулагчийн 01 дугаар шийдвэрээр Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани хэлбэрээр үүсгэн байгуулагдсан. | | |
| Гэрчилгээ | 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр Хуулийн Этгээдийн Улсын Бүртгэлийн Газарт бүртгүүлсэн ба 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдөр компанийн үйл ажиллагаанд орсон нэмэлт өөрчлөлтүүдийг тусган 9011838466 хувийн хэргийн дугаартай, 000256640 тоот улсын бүртгэлийн гэрчилгээг авсан. Компанийн регистрийн дугаар 6852688. | | |
| Тусгай зөвшөөрөл | Монгол Улсын Санхүүгийн Зохицуулах Хорооны 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 273 дугаар тогтоолоор “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах” үйл ажиллагаа эрхлэх ТЗ 315/42 дугаартай тусгай зөвшөөрлийн | | |
| Хувьцаа эзэмшигч | Ашид Капитал ББСБ ХХК | Хувьцааны тоо | Эзэмшлийн хувь |
| | | 1 | 100% |
| Албан хаяг | Симпл Ассет ТЗК ХХК Сэнтрал Тауэр, 12 давхар Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Улаанбаатар хот, Монгол Улс | | |
| Аудитор | Мэжик Консалтинг Аудит ХХК Мэргэшсэн нягтлан бодогчид Юу Би тауэр, 15 давхар, 1502 тоот Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж Баянзүрх дүүрэг, 43-р хороо, Улаанбаатар хот, Монгол Улс | | |

**2023 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
санхүүгийн тайлан бэлтгэх болон батлах талаарх
Удирдлагын Хариуцлагын Мэдэгдэл**

Энэхүү мэдэгдэл нь Симпл Ассет ТЗК ХХК-ийн (Цаашид "Компани" гэх) 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг ялгахад чиглэгдсэн болно.

Компанийн удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС")-ын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй. Бид эдгээр санхүүгийн тайлантай холбоотой үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС"), Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох эрх бүхий байгууллагаас гаргасан заавар журмын дагуу үнэн зөв, шударгаар бэлтгэсэн гэдгээ баталж байна.

Компанийн 2023 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрч батлав.


УЛААНБААТАР ХОТ
**СИМПЛ
АССЕТ ТЗК**
Б. Энхмандах
Б. Энхмандах
902.2060074
Татан буулгах комиссын дарга


З. Динасыл
Татан буулгах комиссын
гишүүн

Огноо: 2024 оны 03 дугаар сарын 29

Улаанбаатар хот



СИМПЛ АССЕТ ТЗК ХХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД-Д

МЭЖИК КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
43-р хороо, Манлай Баатар Дамдинсүрэнгийн
гудамж, UB tower, 15 давхар, 1502 тоот.
Утас: 7288-7288. И-мэйл: info@magicgroup.mn
Вэб хуудас: www.magicgroup.mn

2024.03.29 дугаар 23-УБ/02/38

танай _____-ны дугаар _____-т

Хараат бус аудиторын дүгнэлт

Дүгнэлт

Бид Симпл Ассет ТЗК ХХК ('Компани' гэх)-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр тасалбар болгосон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар компанийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болгосон санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайд, Санхүүгийн Зохицуулах Хороо ('СЗХ')-оос баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт ('АОУС')-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл ('НБЭЗОУСЗ')-ийн Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсад мөрдүүлэхээр шаарддаг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу Группээс хараат бус байсан бөгөөд НБЭЗОУСЗ-ийн дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагын дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан санал дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж бид найдаж байна.

Санхүүгийн тайланд Удирдлага ба Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага.

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС")-ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах, болон алдаа юм уу заль мэхнээс үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайлан бэлтгэх боломж бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг тодорхойлох нь удирдлагын үүрэг хариуцлага юм.

Санхүүгийн тайланг бэлтгэж байхдаа удирдлага нь компанийг татан буулгах юм уу үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд удирдлага өөдрөг төсөөллөөр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх Группийн чадамжийг үнэлж, шаардлагатай бол өөдрөг төсөөлөлтэй холбоотой асуудлуудын талаар тодруулга хийх, нягтлан болох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ. Засаглах удирдлага нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх үл үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилангаас эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үзнэ.

Бид аудитыг гүйцэтгэхдээ АОУС-ын дагуу мэргэжлийн шийдэл гаргаж, аудитын туршид мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг. Түүнчлэн бид Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээсэн үүрэг хариуцлагын тодорхойлолтыг Мэжик Консалтинг Аудит ХХК-ийн <http://www.magicgroup.mn/mn/uureg> веб сайтад байршуулсан. Уг тодорхойлолт нь аудиторын тайлангийн нэг хэсэг юм.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ ба хугацаа, аудитынхаа явцад олж илрүүлсэн дотоод хяналт дахь томоохон зөрчил дутагдлыг оруулаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад асуудлуудаар засаглах эрх бүхий удирдлагатай харилцдаг.

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээлэлд үүрэг хариуцлага хүлээдэг. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон бидний аудиторын тайлан ордоггүй. Санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамардаггүй бөгөөд бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажилтын дүгнэлт гаргахгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбогдуулан бидний хүлээх үүрэг хариуцлага бол бусад мэдээллийг уншиж, ингэснээр бусад мэдээлэл нь нэгтгэсэн санхүүгийн тайлан эсвэл аудитаар олж авсан бидний мэдлэг эсвэл өөр хэлбэрээр материаллагаар буруу илэрхийлэгдсэн байж болох эсэх тухай материаллаг үл нийцлийг авч үзэхэд оршдог. Бид өөрсдийн гүйцэтгэсэн ажил дээрээ суурилан энэхүү бусад мэдээлэл нь материаллаг буруу илэрхийлэлтэй байна гэж дүгнэвэл тухайн бодит байдлыг тайлагнахыг биднээс шаарддаг. Бидэнд ингэж тайлагнах зүйл байхгүй болно.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 95.1-р зүйлд заасан хуулийн этгээд болох Симпл Ассет ТЗК ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



С.МӨНХБАЯР
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ, ПАРТНЕР,
МЭЖИК КОНСАЛТИНГ АУДИТ ХХК
УЛААНБААТАР ХОТ, МОНГОЛ УЛС

2024 оны 03 дугаар сарын 29-ний өдөр

| | Тод | (Мянган төгрөг) | |
|---|-----|----------------------|----------------------|
| | | 2023 оны 12 сарын 31 | 2022 оны 12 сарын 31 |
| Хөрөнгө | | | |
| Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө | 5 | 9,295 | 485,767 |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 6 | - | 40,444,238 |
| Дансны болон бусад авлага | 7 | - | 9,029,706 |
| Нийт хөрөнгө | | 9,295 | 49,959,711 |
| Өр төлбөр ба өмч | | | |
| Өр төлбөр | | | |
| Богино хугацаат өрийн бичиг | 8 | - | 49,631,522 |
| Дансны болон бусад өглөг | 9 | 1,731,787 | 306,284 |
| Орлогын албан татварын өглөг | 10 | - | 71,562 |
| Нийт өр төлбөр | | 1,731,787 | 50,009,368 |
| Өмч | | | |
| Хувьцаат капитал | 11 | 1,000 | 1,000 |
| Хуримтлагдсан ашиг (алдагдал) | 12 | (1,723,492) | (50,657) |
| Нийт өмч | | (1,722,492) | (49,657) |
| Нийт өр төлбөр ба өмч | | 9,295 | 49,959,711 |

Хуудас 9-15-д харуулсан тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

| | Тод | (Мянган төгрөг) | |
|--|-----|--------------------|------------------|
| | | 2023 он | 2022 он |
| Хүүгийн орлого | 13 | 7,033,321 | 6,007,981 |
| Хүүгийн зардал | 14 | (5,778,683) | (4,168,661) |
| Хүүгийн цэвэр орлого | | 1,254,638 | 1,839,320 |
| Зээлийн эрсдэлийн сангийн зардал | 15 | (1,567,419) | (927,353) |
| Зээлийн эрсдэлийн сангийн дараах хүүгийн цэвэр орлого | | (312,781) | 911,967 |
| Үйл ажиллагааны бусад зардал | 16 | (1,264,864) | (883,222) |
| Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | | (1,577,645) | 28,745 |
| Орлогын татварын зардал | 17 | (95,190) | (79,402) |
| Тайлант жилийн цэвэр ашиг (алдагдал) | | (1,672,835) | (50,657) |

Хуудас 9-15-д харуулсан тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

| | (Мянган төгрөг) | | | |
|--|-----------------|-----------------------------------|-------------------------------|--------------------|
| | Өмч | Эздийн өмч бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
| 2023 оны 01 сарын 01-ний үлдэгдэл | 1,000 | - | (50,657) | (49,657) |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | - | - | - |
| Залруулсан үлдэгдэл | 1,000 | - | (50,657) | (49,657) |
| Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/ | - | - | (1,672,835) | (1,672,835) |
| Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | - | - |
| Өмчид гарсан өөрчлөлт | - | - | - | - |
| Зарласан ногдол ашиг | - | - | - | - |
| 2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 1,000 | - | (1,723,492) | (1,722,492) |
| | Өмч | Эздийн өмч бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
| 2022 оны 01 сарын 01-ний үлдэгдэл | - | - | - | - |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | - | - | - |
| Залруулсан үлдэгдэл | - | - | - | - |
| Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/ | - | - | (50,657) | (50,657) |
| Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | - | - |
| Өмчид гарсан өөрчлөлт | 1,000 | - | - | 1,000 |
| Зарласан ногдол ашиг | - | - | - | - |
| 2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 1,000 | - | (50,657) | (49,657) |

Хуудас 9-15-д харуулсан тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

| | Тод | (Мянган төгрөг) | |
|---|-----|---------------------|---------------------|
| | | 2023 он | 2022 он |
| Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | | |
| Тайлант жилийн татварын өмнөх ашиг | | (1,577,645) | 28,745 |
| Тохируулга: | | | |
| Зээлийн үнэ цэнийн бууралтын гарз | 15 | 1,567,419 | 927,352 |
| Ажлын капиталын өөрчлөлтөөс өмнөх үйл | | (10,226) | 956,097 |
| Ажлын капиталын өөрчлөлт: | | | |
| Харилцагчдад олгосон зээлийн (өсөлт)/бууралт | | 37,323,029 | (41,371,591) |
| Дансны болон бусад авлагын (өсөлт)/бууралт | | 8,521,547 | (8,521,547) |
| Дансны болон бусад өглөгийн өсөлт/(бууралт) | | 2,003,639 | (271,852) |
| Үндсэн үйл ажиллагаанаас олсон мөнгө | | 47,837,989 | (49,208,893) |
| Хүлээн авсан хүү | | 7,541,479 | (508,158) |
| Төлсөн хүү | | (5,689,188) | 209,658 |
| Төлсөн орлогын албан татвар | | (166,752) | (7,840) |
| Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | | 49,523,528 | (49,515,233) |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн | | | |
| Үндсэн хөрөнгийн худалдан авалт | | - | - |
| Биет бус хөрөнгийн худалдан авалт | | - | - |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр | | - | - |
| Санхүүжилтийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | | |
| Өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 8 | - | 50,000,000 |
| Өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн | 8 | (50,000,000) | - |
| Хувьцаа гаргаснаас хүлээн авсан | 11 | - | 1,000 |
| Санхүүжилтийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн | | (50,000,000) | 50,001,000 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр | | (476,472) | 485,767 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний | | 485,767 | - |
| Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө | | - | - |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн | | 9,295 | 485,767 |

Хуудас 9-15-д харуулсан тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

1. Тайлагнагч аж ахуйн нэгж

Симпл Ассет ТЗК ХХК (Цаашид "Компани" гэх) нь анх 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр үүсгэн байгуулагчийн 01 дугаар шийдвэрээр Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани хэлбэрээр үүсгэн байгуулагдсан.

2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр Хуулийн Этгээдийн Улсын Бүртгэлийн Газарт бүртгүүлсэн ба 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдөр компанийн үйл ажиллагаанд орсон нэмэлт өөрчлөлтүүдийг тусган 9011838466 хувийн хэргийн дугаартай, 000256640 тоот улсын бүртгэлийн гэрчилгээг авсан. Компанийн регистрийн дугаар 6852688.

Монгол Улсын Санхүүгийн Зохицуулах Хорооны 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 273 дугаар тогтоолоор "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах" үйл ажиллагаа эрхлэх ТЗ 315/42 дугаартай тусгай зөвшөөрлийн гэрчилгээ авсан.

Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 1,000.0 мянган төгрөг ба 1,000.0 мянган төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 1 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ.

Компанийн гаргасан хувьцааг хувь нийлүүлэгч нь дараах байдлаар эзэмшиж байна.

| Хувьцаа эзэмшигчийн нэр | Нэгж хувьцааны үнэ (мянган төгрөг) | Тоо (ширхэг) | Нийт үнэ (мянган төгрөг) | Нийт хувьцаанд эзлэх хувь |
|-------------------------|---------------------------------------|-----------------|-----------------------------|------------------------------|
| Ашид Капитал ББСБ ХХК | 1,000.00 | 1 | 1,000.0 | 100% |

Компани нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 2 ажилтан (2022: 2)-тай байсан.

Компанийн албан ёсны хаяг байршил нь: Монгол улс, Улаанбаатар хот-15160, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сэнтрал тауэр, 12 давхар

2. Тайлан бэлтгэсэн үндэслэл

Компанийн санхүүгийн тайлангууд Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл ("НББОУСЗ")-өөс гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС") болон тайлбаруудын дагуу бэлтгэсэн.

Компанийн Бүртгэлийн мөнгөн тэмдэгт нь түүний үйл ажиллагаа явуулж буй эдийн засгийн орчны үндсэн мөнгөн тэмдэгт байна. Компанийн бүртгэлийн болон тайлагналын мөнгөн тэмдэгт нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөг юм. Эдгээр санхүүгийн тайлангуудад өөрөөр тусгайлан зааснаас бусад тохиолдолд бүх үзүүлэлтүүд мянганчлан илэрхийлэгдсэн.

Компанийн санхүүгийн тайлангууд нь "СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр - бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх"-с бусад зүйлсийн хувьд түүхэн өртгийн зарчмаар бэлтгэсэн болно. Түүхэн өртөг нь хөрөнгийг худалдан авах үед төлсөн эсвэл солилцсон зүйлийн бодит үнэ цэнэ байдаг.

3. Шинээр батлагдсан, нэмэлт өөрчлөлт орсон стандарт болон тайлбарууд

3.1. 2023 оны 01 сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөх шинэ стандарт, түүний тайлбарууд болон нэмэлт өөрчлөлтүүд

- СТОУС 17 "Даатгалын гэрээ" (2017 оны 05 сарын 18-ны өдөр батлагдсан бөгөөд 2023 оны 01 сарын 01-ний өдөр болон түүнээс хойших тайлант хугацаанд дагаж мөрдөнө.)
- СТОУС 17 болон СТОУС 4-т орсон нэмэлт өөрчлөлтүүд (2020 оны 06 сарын 25-ны өдөр батлагдсан бөгөөд 2023 оны 01 сарын 01-ний өдөр болон түүнээс хойших тайлант хугацаанд дагаж мөрдөнө.)
- СТОУС 17 Нэмэлт өөрчлөлт "Даатгагчдын шилжих сонголт" (2021 оны 12 сарын 09-ний өдөр батлагдсан бөгөөд 2023 оны 01 сарын 01-ний өдөр болон түүнээс хойших тайлант хугацаанд дагаж мөрдөнө.)
- НББОУС 12 Нэмэлт өөрчлөлт "Нэг гүйлгээнээс үүссэн хөрөнгө, өр төлбөртэй холбоотой хойшлогдсон татвар" (2021 оны 05 сарын 07-ны өдөр батлагдсан бөгөөд 2023 оны 01 сарын 01-ний өдөр болон түүнээс хойших тайлант хугацаанд дагаж мөрдөнө.)
- НББОУС 1 болон СТОУС-ын практик мэдэгдэл 2-д оруулсан нэмэлт өөрчлөлт "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулга" (2021 оны 02 сарын 12-ны өдөр батлагдсан бөгөөд 2023 оны 01 сарын 01-ний өдөр болон түүнээс хойших тайлант хугацаанд дагаж мөрдөнө.)
- НББОУС 8 Нягтлан бодох бүртгэлийн тооцооллыг тодорхойлох тухай нэмэлт өөрчлөлт (2021 оны 02 сарын 12-ны өдөр батлагдсан бөгөөд 2023 оны 01 сарын 01-ний өдөр болон түүнээс хойших тайлант хугацаанд дагаж мөрдөнө.)

Дээрх шинэ стандарт болон стандартуудын нэмэлт өөрчлөлт нь Компанийн санхүүгийн тайланд материаллаг нөлөөлөл үзүүлээгүй.

3.2. Хараахан мөрдөгдөж эхлээгүй байгаа шинэ стандартууд, түүний тайлбарууд болон нэмэлт өөрчлөлтүүд

- СТОУС 16 Түрээс-т орсон нэмэлт өөрчлөлтүүд: Борлуулаад эргүүлэн түрээслэх түрээсийн өр төлбөр (2022 оны 09 сарын 22-ны өдөр батлагдсан бөгөөд 2024 оны 01 сарын 01-ний өдөр болон түүнээс хойших тайлант хугацаанд дагаж мөрдөнө.)
- НББОУС 1-д орсон нэмэлт өөрчлөлт "Өр төлбөрийг богино болон урт хугацаатайгаар нь ангилах" (анх 2020 оны 01 сарын 23-нд батлагдан, 2020 оны 07 сарын 15 болон 2022 оны 10 сарын 31-нд нэмэлт өөрчлөлтүүд орсон ба 2024 оны 01 сарын 01-ний өдөр болон түүнээс хойших тайлант хугацаанд дагаж мөрдөнө.)
- НББОУС 7 болон СТОУС 7-д орсон нэмэлт өөрчлөлт "Нийлүүлэгчийн санхүүжилтийн зохицуулалтын тодруулга" (2023 оны 05 сарын 25-ны өдөр батлагдсан бөгөөд 2024 оны 01 сарын 01-ний өдөр болон түүнээс хойших тайлант хугацаанд дагаж мөрдөнө.)
- НББОУС 21 Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө-д орсон "Арилжааны алдагдлын талаарх" нэмэлт өөрчлөлт (2023 оны 08 сарын 15-ны өдөр батлагдсан бөгөөд 2025 оны 01 сарын 01-ний өдөр болон түүнээс хойших тайлант хугацаанд дагаж мөрдөнө.)

Компани нь эдгээр шинэ болон нэмэлт өөрчлөлт орсон стандартуудын нөлөөллийг үнэлэх ажлыг хийж байгаа болно.

4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо

4.1. Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө

Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгөд үнэ цэний өөрчлөлтөөс өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, түргэн борлогдох чадвартай касс дахь бэлэн мөнгө, банкин дахь харилцах, хадгаламж, санхүүгийн хөрөнгүүд багтана. Тухайлбал, анх гаргасан хугацаанаас хойш 90 хоног (3 сар)-оос дээш хугацаатай, ямар нэгэн нөхцөлөөр хязгаарлагдсан мөнгөн хөрөнгийг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд оруулахгүй.

4.2. Харилцагчдад олгосон зээл, зээлийн эрсдэлийн сан

Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааг хорогдуулсан өртгөөр хэмжиж, тайлагнана. Зээлийн хорогдуулсан өртөг нь зээлийг анх хүлээн зөвшөөрч хэмжсэн дүнгээс буцаан төлсөн зээлийн үндсэн төлбөрийн төлөлтийг хасаж, хойшлогдсон орлого, зардлыг үр ашигт хүүгийн аргаар хорогдуулан хуримтлуулсан дүнг хасах, эсхүл нэмж, зээлийн эрсдэлийн санг хассан дүн байна.

Зээлийн эрсдэлийн сан нь санхүүгийн хөрөнгийн төлбөр барагдуулахаар хүлээгдэж буй хугацаанд зээлийн алдагдлын магадлалаар жинлэсэн тооцоолол буюу бүх мөнгөн алдагдлын өнөөгийн үнэ цэнэ бөгөөд мөнгөн алдагдал нь гэрээний дагуу төлөгдөх ёстой мөнгөн гүйлгээ ба компанийн авахаар хүлээж буй мөнгөн гүйлгээний хоорондох зөрүү юм.

4.3. Хувьцаат капитал

Компанийн гаргасан санхүүгийн хэрэгслүүд санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн шалгуурыг хангахгүй байх тохиолдолд л тэднийг өмчөөр ангилна. Компани энгийн хувьцаагаа өмчийн хэрэглүүр гэж ангилсан.

4.4. Хүүгийн орлого

Хүүгийн орлого нь тодорхой гэрээний үндсэн дээр зээлдэгчдэд олгосон зээл, бусад банк санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгийг ашиглуулсны төлөө авч буй төлбөр юм.

Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн түвшинг ашиглан тооцож, үнэлнэ. Гэрээний дагуу нэмэлт төлбөр, хойшлогдсон орлого, зардал гараагүй нөхцөлд хүүгийн орлогыг гэрээнд заасан нэрлэсэн хүүгийн хувь хэмжээгээр тооцож, үнэлнэ. Хямдруулалт, урамшуулал, хойшлуулсан орлого, зардлыг холбогдох санхүүгийн хэрэгслийн хугацаанд үр ашигт хүүгийн аргаар хуваарилж, бүртгэнэ.

4.5. Хүүгийн зардал

Хүүгийн зардлыг үр ашигт хүүгийн түвшнээр тооцож үнэлнэ. Татан төвлөрүүлсэн эх үүсвэртэй холбоотой нэмэлт урамшуулал, хямдруулалт, хойшлогдсон орлого болон зардал гараагүй нөхцөлд хүүгийн зардлыг гэрээнд заасан нэрлэсэн хүүгийн хувь хэмжээгээр тооцож, үнэлнэ.

4.6. Үйл ажиллагааны бусад зардал

Үйл ажиллагааны бусад зардалд үндсэн үйл ажиллагаатай холбогдон гарч байгаа цалин хөлс, татвар, шимтгэл гэх мэт удирдлага, борлуулалтын зардал багтана. Үйл ажиллагааны бусад зардлыг төрөл тус бүрээр ангилж, бүртгэнэ.

4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

4.7. Орлогын татварын зардал

Орлогын татварын зардал нь тухайн жилд төлөхөөр тооцсон татвар хойшлогдсон татварын нийлбэрээс бүрдэнэ.

Тухайн жилийн орлогын албан татвар

Тухайн жилийн татварын өглөг нь тухайн жилийн татвар ногдуулах орлогод суурилсан байна. Татвар ногдуулах орлого нь Компанийн санхүүгийн тайлангаар тодорхойлсон ашгаас зөрүүтэй байдаг нь санхүүгийн тайланд тусгагдсан орлого, зарлагын зүйлсийн татвар ногдох, татвар ногдох орлогоос хасагдах хугацаа нь татварын тайлангийн зорилгоор өөр тайлант хугацаанд үүсдэг эсвэл эдгээр нь огт татвар ногдохгүй эсвэл татвар ногдох орлогоос хасагдахгүй байдагтай холбоотой. Компанийн тухайн жилийн татварын өрийг тайлант өдрөөр хүчин төгөлдөр эсвэл хүчин төгөлдөр болох нь тодорхой татварын хувь хэмжээгээр тооцож, тодорхойлно.

Хойшлогдсон татвар

Хойшлогдсон татварыг санхүүгийн тайлан дахь хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ болон татвар ногдуулах орлогыг тооцоход хэрэглэсэн тэдгээрийн татварын суурь хоёрын хоорондын түр зөрүүнд тооцдог. Ерөнхийдөө бүх татвар ногдох түр зөрүүгээр хойшлогдсон татварын өрийг бүртгэдэг. Хойшлогдсон татварын хөрөнгийг бараг бүх хасагдах түр зөрүүнд тооцдог боловч ирээдүйд тэдгээр хасагдах түр зөрүүг шингээхэд хүрэлцэхүйц татвар ногдуулах ашигтай байх өндөр магадлалтай эсэхийг харгалздаг. Эдгээр хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийг гүүдвил болон татварын ногдуулах орлого ба санхүүгийн ашгийн аль алинд нь нөлөөлдөггүй ажил гүйлгээ (бизнесийн нэгдлээс бусад)-ний үед бусад хөрөнгө, өр төлбөрийг анх бүртгэхэд үүссэн түр зөрүүгээр бүртгэдэггүй.

Хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг тайлант хугацааны эцэст хянаж үздэг ба уг хөрөнгийг болон хөрөнгийн зарим хэсгийг нөхөхөд хүрэлцэхүйц татвар ногдуулах ашигтай байх магадлал бага болсон бол дансны үнийг бууруулдаг. Тайлант жилийн татварын зардал нь тухайн жилийн татвар ногдуулах орлогод санхүүгийн байдлын тайлангийн өдрөөр хүчин төгөлдөр эсвэл хүчин төгөлдөр болох нь тодорхой татварын хувь хэмжээг ашиглан ногдуулсан татварын өр болон өмнөх жилүүдийн татварын өртэй холбоотой залруулгаас бүрдэнэ.

Хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийг уг татварыг үүсгэж байгаа хөрөнгө, өр төлбөрийг борлуулах, барагдуулах үеийн татварын хувийг ашиглан хэмжих ба тайлант өдрөөр хүчин төгөлдөр эсвэл хүчин төгөлдөр болох нь тодорхой татварын хувь хэмжээгээр тооцож, тодорхойлно. Хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийг хэмжихдээ уг татварыг үүсгэж байгаа хөрөнгө, өр төлбөрийг тайлант өдрийн байдлаар Компани хэрхэн борлуулах, барагдуулахаар төлөвлөж байгаа ба түүнээс хамаарсан татварын нөлөөллийг тусгасан байх ёстой.

Тухайн жилийн болон хойшлогдсон татвар

Тухайн жилийн болон хойшлогдсон татварыг тайлант жилийн ашиг алдагдлаар бүртгэх ба харин тэдгээр нь иж бүрэн орлого эсвэл өмчийн хэсэгт шууд бүртгэгдсэн зүйлстэй холбоотой бол харгалзан иж бүрэн орлого эсвэл өмчин хэсэгт бүртгэдэг. Тухайн жилийн болон хойшлогдсон татвар нь бизнесийн нэгдлийг анх бүртгэхтэй холбоотой бол татварын нөлөөллийг бизнесийн нэгдлийн бүртгэлд оруулж тусгана.

5 Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө

| | 2023 оны 12 сарын 31 | (мянган төгрөг) 2022 оны 12 сарын 31 |
|---------------------------|----------------------|---|
| Банкин дахь харилцах данс | 9,295 | 485,767 |
| | 9,295 | 485,767 |

6. Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа

| | 2023 оны 12 сарын 31 | (Мянган төгрөг) 2022 оны 12 сарын 31 |
|-----------------------|----------------------|---|
| Зээлийн авлага | - | 41,371,591 |
| Зээлийн эрсдэлийн сан | - | (927,353) |
| | - | 40,444,238 |

7. Дансны болон бусад авлага

| | 2023 оны 12 сарын 31 | (Мянган төгрөг) 2022 оны 12 сарын 31 |
|------------------------------------|----------------------|---|
| Хуримтлуулан тооцсон хүүний авлага | - | 508,158 |
| Холбоотой талаас авах авлага | - | 8,521,547 |
| | - | 9,029,706 |

8. Богино хугацаат өрийн бичиг

| | 2023 оны 12 сарын 31 | (Мянган төгрөг) 2022 оны 12 сарын 31 |
|--|----------------------|---|
| Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны өглөг | - | 49,631,522 |
| | - | 49,631,522 |

9. Дансны болон бусад өглөг

| | 2023 оны 12 сарын 31 | (Мянган төгрөг) 2022 оны 12 сарын 31 |
|-----------------------------------|----------------------|---|
| Дансны өглөг | - | 3,000 |
| Хуримтлуулан тооцсон хүүний өглөг | - | 209,658 |
| Холбоотой талд өгөх өглөг | 1,731,787 | - |
| Татвар, НДШ-ийн өглөг | - | 93,626 |
| | 1,731,787 | 306,284 |

10. Орлогын албан татварын өглөг

| | 2023 оны 12 сарын 31 | (Мянган төгрөг) 2022 оны 12 сарын 31 |
|------------------------------|----------------------|---|
| Орлогын албан татварын өглөг | - | 71,562 |
| | - | 71,562 |

11. Хувьцаат капитал

| | (Мянган төгрөг) | |
|----------------|-------------------------|-------------------------|
| | 2023 оны 12 сарын 31 | 2022 оны 12 сарын 31 |
| Энгийн хувьцаа | 1,000 | 1,000 |
| | 1,000 | 1,000 |

12. Хуримтлагдсан ашиг (алдагдал)

| | (Мянган төгрөг) | |
|----------------------|-------------------------|-------------------------|
| | 2023 оны 12 сарын 31 | 2022 оны 12 сарын 31 |
| Тайлант үеийн ашиг | (1,672,835) | (50,657) |
| Өмнөх үеийн алдагдал | (50,657) | - |
| | (1,723,492) | (50,657) |

13. Хүүгийн орлого

| | (Мянган төгрөг) | |
|---------------------------------------|------------------|------------------|
| | 2023 он | 2022 он |
| Зээлийн хүүгийн орлого | 6,081,423 | 6,007,981 |
| Харилцах, хадгаламжийн хүүгийн орлого | 951,898 | - |
| | 7,033,321 | 6,007,981 |

14. Хүүгийн зардал

| | (Мянган төгрөг) | |
|------------------------|--------------------|--------------------|
| | 2023 он | 2022 он |
| Зээлийн хүүгийн зардал | (5,778,683) | (4,168,661) |
| | (5,778,683) | (4,168,661) |

15. Зээлийн эрсдэлийн сангийн зардал

| | (Мянган төгрөг) | |
|----------------------------------|--------------------|------------------|
| | 2023 он | 2022 он |
| Зээлийн эрсдэлийн сангийн зардал | (1,567,419) | (927,353) |
| | (1,567,419) | (927,353) |

16. Үйл ажиллагааны бусад зардал

| | (Мянган төгрөг) | |
|---|--------------------|------------------|
| | 2023 он | 2022 он |
| Үндсэн болон нэмэгдэл цалин | (20,000) | (15,185) |
| Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал | (2,460) | (1,673) |
| Нотариат, бусад төлбөр хураамж | (1,036) | (394) |
| Аудит, үнэлгээ | (300) | (136,000) |
| Банкны үйлчилгээний зардал | (191,685) | (318) |
| ХБҮЦ багцын зээлийн төлбөр цуглуулахтай холбоотой | (1,049,383) | (729,654) |
| | (1,264,864) | (883,222) |

17. Орлогын татварын зардал

| | (Мянган төгрөг) | |
|---|-----------------|-----------------|
| | 2023 он | 2022 он |
| Тайлант үеийн орлогын албан татварын зардал | (95,190) | (79,402) |
| | (95,190) | (79,402) |

18. Холбоотой талуудын тодруулга

18.1. Холбоотой талуудыг тодорхойлох

Компанийн санхүүгийн болон бусад үйл ажиллагаатай холбоотой хяналт хэрэгжүүлдэг талууд болон түүнтэй шууд хамааралтай талуудыг холбоотой тал гэж үзэх бөгөөд холбоотой талууд нь хувь хүмүүс, аж ахуйн нэгж байгууллагууд байж болно.

Компанийн холбоотой талууд болон тэдгээрийн харилцан хамаарлыг харуулбал:

| Холбоотой талууд | Оролцоо | Хамаарал |
|-----------------------|---------|----------------|
| Ашид Капитал ББСБ ХХК | 100% | Толгой компани |
| Юнител ХХК | - | Бусад хамаатай |
| Пайнкоун ХХК | - | Бусад хамаатай |

18.2. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний тооцооны үлдэгдэл

Тайлант хугацааны эцэст холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний тооцооны үлдэгдлийг доор харууллаа.

| | (Мянган төгрөг) | |
|-------------------------------------|----------------------|----------------------|
| | 2023 оны 12 сарын 31 | 2022 оны 12 сарын 31 |
| Холбоотой талаас авах авлага | | |
| Ашид Капитал ББСБ ХХК | - | 8,521,547 |
| | - | 8,521,547 |
| Холбоотой талд өгөх өглөг | | |
| Юнител ХХК | - | 30,000,000 |
| Пайнкоун ХХК | - | 1,500,000 |
| Ашид Капитал ББСБ ХХК | 1,731,787 | - |
| | 1,731,787 | 31,500,000 |

19. Хүлээж болзошгүй үүрэг хариуцлага

Бизнесийн хэвийн явцад компани нь түүний эсрэг нэхэмжлэл хүлээн авч болно. Компанийн удирдлага эдгээр нэхэмжлэлүүдээс үүдэлтэйгээр ирээдүйд материаллаг алдагдалд орж болзошгүй тул шаардлагатай сэргийлэх арга хэмжээг авах нь зүйтэй юм.

Шүүхийн нэхэмжлэл

2023 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар Симпл Ассет ТЗК ХХК-ийн эсрэг гаргасан ямар нэг томоохон зарга маргаан, шийдвэрлэгдээгүй нэхэмжлэл байгаагүй. Өөрөөр хэлбэл, байгууллагын ирээдүйн тасралтгүй үйл ажиллагаа явуулах чадварт эргэлзээ төрүүлэхүйц болзошгүй өр төлбөрийн эрсдэл байхгүй байна.

20. Тайлангийн дараах үйл явдал

Компанийн удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудад нөлөөлөхүйц, тодруулахыг шаарддаг үйл явдал тайлант хугацаа дуусгавар болсон өдрөөс хойш санхүүгийн тайланг хэвлэн нийтлэхийг зөвшөөрсөн өдрийг хүртэл гараагүй гэж үзэж байна.



МЭЖИК КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

Хэмжиж үл чадвал, Удирдаж үл чадна



7288-7288
8811-2064



www.magicgroup.mn
audit@magicgroup.mn



Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
43-р хороо, UB Tower, 15-р давхарт, 1502 тоот